


Ипотекийн зээлийн тайлан

2016 оны 2 дугаар сар


Банкууд 2016 оны 2 дугаар сард нийт 773 зээлдэгчид 46.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3459.6 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 77673-д хүрчээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 1.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 21.7 нэгж хувиар тус тус буурсан байна.



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.8 хувь буюу 2623.8 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 22.3 хувь буюу 771.8 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.8 хувь буюу 63.9

тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



2016 оны 2 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэлийн 98.7 хувь нь төгрөгийн зээл, 1.3 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2016 оны 2 дугаар сарын байдлаар 3.2 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.8 байна.




Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 94.6 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.1 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 83.1 хувь буюу 38.6 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 16.9 хувь буюу 7.8 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 2 дугаар сарын байдлаар 60.0 сая төгрөг байна.

Тухайн сард 22.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 33.6 хувиар буурчээ.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 773 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 622 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 151 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

2016 оны 2 дугаар сарын байдлаар нийт 77673 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 56577 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 19161 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1935 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хүү

Банкуудын 2016 оны 2 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 9.2 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 7.4 нэгж хувиар буурсан байна.

Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 3.0 сараас 20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.6 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2016 оны 2 дугаар сарын байдлаар 15.6 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 56.8 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.3 хувь нь 16-20 жил, 17.2 хувь нь 11-15 жил, 9.6 хувь нь 6-10 жил, 2.2 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.1 хувь байв.



Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХҮҮ, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2008	12	217,977.5		8.4	19.8	16,522	
2009	12	226,040.6		8.6	18.7	16,784	
2010	12	333,776.6		9.6	16.0	16,700	
2011	12	669,662.8		12.9	14.8	26,869	
2012	12	845,204.4		13.0	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	16.1	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	16.2	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	16.1	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	15.9	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	16.0	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	15.8	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	15.2	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	15.7	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	15.6	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	15.5	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	15.8	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	16.2	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	16.7	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	16.3	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	16.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	16.5	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	16.6	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	16.4	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	16.4	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	16.1	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	16.3	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	16.2	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	16.8	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	16.4	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6	16.7	8.8	77,105	55,830
2016	1	3,434,849.9	2,595,234.1	16.3	10.1	77,226	56,031
	2	3,459,596.6	2,623,837.0	16.6	9.2	77,673	56,577

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 2 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХүү	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,673,139.8	77.27	1,991,230.5	75.89	16.9	8.8	52923	39,371
2 Дархан-Уул	115,506.3	3.34	101,914.2	3.88	16.5	8.7	3421	2,862
3 Орхон	110,520.6	3.19	97,249.6	3.71	16.4	8.8	2917	2,471
4 Дорноговь	71,700.8	2.07	59,626.4	2.27	17.3	8.6	2075	1,648
5 Дорнод	50,279.1	1.45	45,310.1	1.73	16.8	7.9	1587	1,332
6 Сэлэнгэ	45,827.3	1.32	36,479.3	1.39	15.0	8.0	1573	1,097
7 Увс	45,430.0	1.31	33,225.1	1.27	14.2	13.9	1481	782
8 Өвөрхангай	43,025.0	1.24	30,768.1	1.17	12.9	7.8	1533	802
9 Өмнөговь	41,406.8	1.20	31,650.8	1.21	16.1	8.0	1161	784
10 Ховд	33,722.8	0.97	28,556.0	1.09	16.3	8.9	1135	848
11 Баянхонгор	29,287.7	0.85	25,666.5	0.98	17.4	8.6	849	719
12 Сүхбаатар	26,944.7	0.78	18,370.1	0.70	17.3	9.0	920	524
13 Архангай	24,138.4	0.70	19,110.8	0.73	18.6	8.5	708	478
14 Баян-Өлгий	22,250.0	0.64	11,987.6	0.46	13.0	7.1	1088	312
15 Говь-Алтай	19,369.3	0.56	15,734.6	0.60	11.2	21.6	629	465
16 Завхан	19,181.3	0.55	12,123.7	0.46	14.2	7.5	700	307
17 Хөвсгөл	17,783.1	0.51	9,704.4	0.37	9.2	7.5	719	221
18 Хэнтий	16,963.5	0.49	14,628.6	0.56	0.0	0.0	505	401
19 Төв	15,610.5	0.45	11,592.7	0.44	16.1	7.2	483	318
20 Дундговь	12,542.3	0.36	11,170.4	0.43	0.0	0.0	410	330
21 Говьсүмбэр	12,542.3	0.36	11,170.4	0.43	0.0	0.0	410	330
22 Булган	12,425.1	0.36	6,567.0	0.25	6.0	12.0	446	175
Нийт	3,459,596.6	100.00	2,623,837.0	100.00	16.7	8.8	77673	56577

2016 оны 2 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.3 хувийг Улаанбаатар хотод, 22.7 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.7 хувь буюу 115.5 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.1 хувь буюу 110.5 тэрбум төгрөг Орхон аймагт, 9.1 хувь буюу 71.7 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.